

**Чингис хааны нэгэн зарлигийн учир,  
ач холбогдол**

**Жалайр Б.Пүрэвсүрэн**

Монголын тулгар төр байгуулагдсаны дараах анагаахын талаар гарсан зарлиг шийдвэртэй түүхийн баримт бичиг олон байдаггүй, харин тод үсгээр бичсэн “Урианхай ардын домын судар”-т Чингис хааны нэг зарлиг байсныг үзэв<sup>1</sup>.

Эл номын эхний хуудас дутуу, харин номын төгсгөлд “Урианхай ардын домын судар болой” хэмээн бичсэн байв. 15x11 см хэмжээний болгомол цаасанд тод хар бэхээр хичээнгүйлсэн 30 хуудастай тод үсгийн мутрын бичиг.

Энэ домын номын 25-30 дугаар хуудсанд “Суут богд Чингис хаан, Цагаадай хаан чиний тэнд эм буй буюу над өгч илгээ хэмээн зарлиг болсонд хаан эм жич илгээвэй” гэсэн гарчигтайгаар эмчилгээний домын 87 зүйл бичсэн байдаг. Бид түүнийг шинжилгээнд зориулж нийтийн хүртээл болгохыг зорьж зүйл тус бүрийн өмнө дугаар тавьж дор сийрүүлэн буулгаж бичив<sup>2</sup>.

**СУУТ БОГД ЧИНГИС ХААН “ЦАГААДАЙ ХААН ЧИНИЙ ТЭНД ЭМ БУЙ БУЮУ НАД ӨГЧ ИЛГЭЭ”  
ХЭМЭЭН ЗАРЛИГ БОЛСОНД ХААН ЭМ ЖИЧ ИЛГЭЭВЭЙ.**

1. Шүд шархиран өвдвөл могойн цөс түрхээд зууж байтал эдгэх.
2. Хүний хамрын цус эс тогтвол (зостон ядвал арудни) гэзэг түлж хамарт үлээвэл тогтоно.
3. Хамраас цус гарч эс тогтвол Алтан хонхорцог /цэцэг/ үлээвэл эдгэнэ.
4. Хамрын цус тогтохгүй бол нохойн баас хусч үлээвэл, дарс ууж бөөлжүүлвэл, бүлээн ус шар тосонд зуурч уувал эдгэнэ.
5. Хүний нууц (төмсөг) хавдвал жодооны холтос чанаж гурилын хэвгээр боовол эдгэнэ.
6. Хүний идээ эс шингэвэл шар тос, чихэр, тараг гурвыг зуурч идвэл эдгэнэ.
7. Саа дайрвал /татвалзан өдөгдөн өвдвөл/ хэрээний цөс өчүүхэн аяга тосонд зуурч ууваас эдгэнэ.
8. Хатан хүн сар илүү тээж (үлүж) нярайлан ядвал хараацайн мах идвэл амаржих.
9. Хүний давсаг өвдвөл болсон шар тос, атга хужир найруулж ууваас эдгэнэ.

<sup>1</sup> Хэдэн жилийн өмнө зурхай судлаач доктор Урианхан овгийн Лхасрангийн Тэрбиш багштан Говь-Алтай аймгийн зарим сумаар орж монгол зурхай, угсаатны шинжилгээнд холбогдох судлагдахуун бүрдүүлж явах зуур өөрийн өвөг дээдсийн олон үе уламжлан хэрэглэж хадгалсан хэсэг тод үсгийн ном байснаа авч ирсний дотор нэг домын ном байсан нь энэ ажээ (Их эмч Жалайр Батын Пүрэвсүрэн).

<sup>2</sup> Эх судрын 25 дугаар хуудас, ар (verso) талын 5 дахь мөрөөс 26 дугаар хуудасны өвөр (recto) тал

10. Чих дүлийрвэл шар гурил дотор амьд чийгийн улаан хорхой /газрын ичдэг улаан хорхой/ хийж туулай цагт ууваас эдгэнэ.
11. Цээж өвдвөл хярын боржин (хүр хадны) хадны хаг, үхрийн эвэр, хавирганд (харвис) нь үрж маргааш нь хүртвэл эдгэнэ.
12. Хүний нүдэнд цагаа унавал ууган хөвүүний шээс, давстай хар цай /чилгийн хар/ хоёрыг дусаавал эдгэнэ.
13. Нүд олингор (хараа муудсанаас ониж харах) болоход хон хэрээний /хараацайн/ цөс түрхвэл эдгэнэ.
14. Нүд харалган болбол тогорууны баас өд түлж нэг халбагыг хүүхдийн шээсэнд буцалгаж уулгавал эдгэнэ.
15. Цээж өвдөж амьсгаа цухалдахад /амь бүтэхэд/ ухны /тэхийн/ хөгөөр чангахан шиг ороолговол /хөвшвөл/ сайн буй.
16. Бэтэгтэй хүн нэг хүжний цагаан үнс /нэг цагаан мөхсөн хүж/, шар тос хольж идвэл гэдэс гүйлгээд эдгэнэ.
17. Хүний хөлс гарвал /хөлс хавчвал/ зээргэний иш буцалгаж уух.
18. Хүйтэн /сэрүүн/ өвчинд гурван аяга ус, нэг хэсэг тос лугаа хийж нэг аягыг өлөн биед уувал эдгэнэ.
19. Хүйтэн /заг/ өвчинд алт хусч тосонд зуурч уувал эдгэнэ.
20. Хүний толгойн үс шингэрвэл /тархай үс/ ямарваа туулай алж балтай хольж хүрэл, гууль түрхвэл эдгэнэ.
21. Эвшээн ядвал үзэм, чихэр, тараг гурвыг хольж уувал эдгэнэ.
22. Нярай хүүхдийн баас, илжигний туурай түлж үнсийг нь усанд зуурч уувал эвшээн ядах эдгэнэ.
23. Гэдэс гүйлгэхэд хитүү /цагаан хойлог/ шувууг үстэй нь шарж идвэл эдгэх.
24. Хүйтэн усыг ханатал ууж хоёр гараа усанд дүрж удваас өвчин намдах сайн.
25. Өвчин хүрвэл туулайн баруун гуя худаг дотор хатгаад идвээс эдгэнэ.
26. Хатан хүн төрөн ядвал хүүлүр сарын найман шинэд алсан туулайн элэг, арьс, үс, галд түлж дарсанд зуурч ууваас төрнө.
27. Эхэс түдвэл зураа халзыг хусч ууваас гарна.
28. Шөнө хүн аймтгай болбол шинэ ургасан бугын эвэр авч яваад хүзүүний махтай олон олон идвэл ямарваа шулмас үл халдана.
29. Хамрын цус эс тогтвол хамраад зээрд мориор амьсгалуулваас тогтоно.
30. Шувууны хөл хавдвал үнэгний цөс түрхвэл эдгэх.
31. Хатан хүн төрөн ядвал хар морины сүүл тосонд зуурч уувал эм.
32. Хатан хүн төрөн ядвал эм оронгын эвэр үгүй бол бугын эвэр, туулайн хоргол, чилээгийн будаг тосонд хийж толгойн орой дээр нь лац наа. Хоёр нэргүй хурууг боо.
33. Эхэс түдвэл хуцын эврээр утаж, толгой хоёр хуруугий нь боо. Давсаг өөд нь илэн барь.
34. Хулгана өвчин, хамуу өвчинд бугын цус уулга.
35. Хон хэрээний мах гэдэс гүйлгэхэд эм.
36. Загасны мах, шингүн хоёр хольж идвэл бэтэг эдгэх.
37. Галд түлэгдсэнд нохойн цус түрх.
38. Булчирхайн хавдар /булчирхай/-т эм хүний толгойн ясны нунтгийг үлээ.
39. Хэжиг урвасанд үхэр бөөрөлзгөний иш, анис хоёрыг хольж буцалгаж өг.
40. Үнэгний мах, чонын мах /оралин/ идвэл уушгины өвчин эдгэх.
41. Алт мөнгө хоёрыг хольж идвэл шар ус арилах.
42. Шизэргэний баас, үсийг цэцгийн шар дэлбээ /хамтгаст/-д нийлүүлж өг, цусаар суулгахад сайн.
43. Аман хүзүү шигдвэл, эгэм мултарвал, морины туурай, тойг /тээг/ яс булгарвал дээсээр оосорлоод модоор цохих ба шарханд нэг цэн алтны төдий хөө уулга. Яс хагарсанд ч болно.
44. Өрц хагарвал лавай /дун/ сүүнд зуурч уу.
45. Элэг бяцарвал амьд нохойн элгээр дар.
46. Ходоодны хорхой хөдөлбөл морины хомоолын шүүс, давс уувал сайн.
47. Хахвал хоёр хөлийг эгэм дээгүүр нугалж /орвол/ гэдэс улыг дэлс.
48. Тэнгэрт ниргүүлж үхсэний яс цахилгаан хийгээд гарьдын аюул, цусаар уруу суулгахын буу болох.

49. Ясанд сум тогтсонд алимны шүүс дусаавал гарна. Мөнгөний ус хийх, зэрлэг сонгино түлж хий. Бас хуучин илэгний хөрс, хуучин тоостой цэмбэ түлж хийвэл болно.
50. Өөөдсөн /өргөдөг/ адгуусны хамрыг бөглөвөл босно. Эцэж туйлдан байвал дөрвөн булчинг /мөчний булчин/ боовол хүч өчүүхэн нэмэх.
51. Гадна зайлсан морины богт чөмгийг боо. Дотор зайлбал хошного өөд нь ус хийж үлээвэл болно. Эгмийн доогуур тэгш боо. Гаргаж үзвээ. Эсвээс хөлөөс нь уя.
52. Тархи унаваас найтаавал эдгэх.
53. Хөлдсөнд дав дээр хөлийн шагайн судас /гөрөөг/ хатгавал болох.
54. Тархины яс хальс хагарсанд ясы нь цоолоод тархинаас авч дундруулаад хальсыг нь эвлүүлээд төөнө.
55. Нуруу хугарвал цөгцөөр товчил /аяга тавьж боо/.
56. Давсагны өвчин болбол хүйтэн усанд оруул.
57. Шээс хаагдвал шар шувууны өд түлээд хярвасы нь усанд зуурч өгвөл туслах.
58. Тэмээний бөөр унавал аль аргаар шилгээлгэвээс эдгэх.
59. Хөлбөрөнгөтвөл /гэдэс түгжирвэл/ хошногонд нь ус хийж үлээвэл болох.
60. Эр хүдрийн сүүл гахайн туруугаар утвал амийн уг тасрах /бүр мөсөн үхэх/.
61. Их сав гарвал /умай унжвал/ олон яс нийлэх дээр /олон ясны уулзварт/ ээрүүл /ийгийн/ иш эргүүл.
62. Шөрмөс татан турууны ирмэгээр гишгэж, шинэ татагч шөрмөснөөс завсартай болгон огтолж авбал тус болох.
63. Гэм болсон морины чихэнд зэсийн үртэстэй давс хийж бөглөвөл тус болох.
64. Идсэн мах шингэхгүй өмхийгөөр хэхэрдэгт хулганы махны шөл, цус уувал тус болох.
65. Арцаар утвал нэг өдрийн халдвар чадах.
66. Хамраас цус гараад тогтохгүй бол явуу түлээд үнсий нь хийвэл түргэн тогтох.
67. Чихнээс булаг гарвал шар явуу түлсэн үнсийг хүний сүүнд зуурч чихэнд хийвэл туслах.
68. Жүр үрийг хар архинд дэвтээгээд долоо хоног түрхвэл үс үлэмж ургах.
69. Эрүү зуурсан морины хамрыг бөглөвөл тус болох.
70. Гэмтсэнд хөхөө усанд дүрвэл тус болох.
71. Хөх хавдвал хавдар дээр загас зурвал болох.
72. Их айваас хүйтэн усанд орвол болох.
73. Гэдсэнд шархтвал морин хулганы задгай шөрмөсөөр оёвол болох.
74. Түнх мултарвал /аяга толгой булгарвал/ моголцог /бөөрөнхий/ утсаар түлхэж гишгэж байгаад хөлөөс дотогш нь татвал болох.
75. Чөмөг хугарвал эрүүл чөмгөөр сацуулж байж гадуур дотуур нь мэдэрч эвлүүлэн баривал болох.
76. нүдэнд үргэлж цагаа унадаг болбол хоёр чихний ирмэг /хөвөө/ дээр төөнө тавивал болох.
77. Хоёр нүдний уг эс сохорвол гэзгийн хонхор дээр төөнөвөл болох.
78. Хамраас цус тогтохгүй бол хар азарганы хомоолын шүүс уувал болох.
79. Чихнээс булаг гарахад луувангийн шүүс хийвэл болох.
80. Шүд өвдөхөд бугын өөхөөр утвал болох.
81. Эхэс түдвэл хонины эвэр, бөхөнгийн эвэр хоёрыг шар архинд зуурч уувал болох.
82. Цусаар туулгавал оронгын цус уухад болох.
83. Гэдэс гүйлгээд тогтохгүй бол үүргэнэ идэж болох. Бас тутарга идэж болно.
84. Морины гэдэс хагарвал хүнийхтэй адил үйлдвэл болно.
85. Сөдрөг гарвал халуун төмрөө давирхайгаар завсарлаж хайрвал болох.
86. Галзуу нохой зуувал хар нохойн соёо уувал тус болох. Хонь, барын цус мах аль олдсоныг идвэл тус болох.
87. Яс хугарваас тутарга хуурч идвээс болох. **Нууц**

гэсэн байна.

Сударчлан бичсэн энэ номын хуудсанд утаа жигдхэн шингэж шарласан бас хуудасны өнцөгт гарын тос шингэж борлосон байх нь хүмүүс их уншиж байсан ном болох нь илэрхий байв.

Энэ домын сударт байгаа зарлиг бол монгол анагаах ухааны түүхэнд холбогдолтой олон шинэ мэдээлэл агуулсан түүхийн ховор дурсгал юм. Зарлигийг эргэцүүлэн судалбаас дундад зууны үеийн монгол анагаах ухааны хөгжлийн төвшин, эмнэлгийн гадаад харилцаа, талын монголчуудын хүн амын өвчлөлтийн байдал, ялангуяа цэргийн хүрээ дэх өвчлөл, эмчилгээний арга барил, цэрэг армийн тогтолцоонд шинжилгээ хийх боломжтой судлагдахуун байна.

### ЭХ БИЧИГТ ГАРСАН ЗАРИМ ҮГИЙН ТАЙЛБАР<sup>3</sup>

Арудни	- гэээг
(Цус) зосто-	- цус гарах
Хүний нууц	- төмсөг
Татвалзан өдөгдөн өвдвөл	- саа дайрах
Газрын ичдэг улаан хорхой	- чийгийн улаан хорхой
Хүрхад	- боржин хад
Мингадар	- маргааш
Чилийн хар	- давстай хар цай
Олингор	- хараа муугаас олийн харах, хялар
Хараацай	- хон хэрээ
Амь бүтэх	- амьсгаа цухалдах
Тэхийн хөг	- ухны хөг
Хөвшвөл	- ороолговол
Мөхсөн хүж	- хүжний үнс
Толгойн үс тархай	- толгойн үс шингэн
Ятуу	- цагаан хойлог
Зурхуу халз	- зураа халзан, соёо халзан, хамар цагаан
Булирхай	- булчирхай
Анжис	- анис жимс
Оралин	- чоно
Шар хамтгас	- цэцгийн шар дэлбээ
Ам нуруу	- аман хүзүү
Гэсэн	- гэдэс
Өргөдөг адгуус	- эцэж тураад өөөдсөн мал
Дөрвөн булчин	- дөрвөн хөлийн булчин, 4 мөчний булчин
Зайлсан морь	- адууны гэдэс ороолдох өвчин
Гөрөөг хатгах	- хөлийн шагайн судас хатгах
Цөгцөөр товчил	- аяга тавьж боох
Тэмээний бөөр унавал	- тэмээний бөөр доргих
Ийгийн иш	- зэрүүлийн иш
Шүүс	- мах
Раг зуусанд	- морь зуурсан, усгүй их цангасан морь
Аяга толгой булгарвал	- жинс булуу гарвал, түнхний үе мултарвал
Эвлүүлэх	- эвлүүлэн барих
Гээгийн хонхор	- шилний хонхор, хулгай гээгийн хонхор
Цусаар туулах	- цустай чацга алдах
Сөдрөг	- адууны өвчин
Гөлчүү нохой	- галзуу нохой

Цагаадай хааны ирүүлсэн домын зүйлийг өвчний нэрээр ангилбал:

Арьсны өвчин анагаах дом /17, 20, 34, 41, 68/ 5

Шүдний өвчин анагаах дом /1, 80/ 2

Цус тогтоох дом /2, 34, 29, 66, 78/ 6

<sup>3</sup> Уг эхэд гарсан дараалалаар жагсаавсан болно.

Төрөх эмэгтэйчүүдийн өвчин анагаах дом /8, 26, 27, 31, 32, 33, 61, 71, 81/ 9

Чихний өвчин анагаах дом /10, 67, 79/ 3

Нүдний өвчин анагаах дом /12, 13, 14, 76, 77/ 5

Хоол боловсруулах эрхтний өвчин анагаах дом /6, 22, 23, 35, 42, 46, 64, 82, 83/ 9

Шээс, бэлэг эрхтний өвчин анагаах дом /5, 9, 18, 19, 56, 57/ 6

Сэтгэл мэдрэлийн өвчин анагаах дом /7, 21, 28, 72/ 4

Халдварт өвчин анагаах дом /16, 25, 36, 39, 65, 86/ 6

Гэмтэл согогийн өвчин анагаах дом /11, 15, 44, 38, 37, 40, 43, 44, 45, 47, 48, 49, 52, 53, 54, 55, 60, 62, 70, 73, 74, 75, 87/ 23

Мал амьтны өвчин анагаах дом /30, 50, 51, 58, 59, 63, 84, 85/ 9 байгааг дотор гэмтэл согогийн өвчний дом хамгийн олон 23 байгаа нь Цагаадай цэргийн хүрээнд зориулж илгээсэн дом засал болохыг харуулж байна.

Энэ тухай эс өгүүлэн өгүүлэх нь юуны урьд Чингис хааны зарлиг гарах үеийн Монгол улсын төр, цэрэг армийн нөхцөл ямар байсныг авч үзэх нь чухал.

Баруун зүгийн байлдан дагуулах ажиллагаа амжилтад хүрч Самаркандад Цагаадай вангаар өргөмжлөгдсөн бөгөөд дорно зүгт Алтан улстай хийсэн дайн төгсөж, Тангуудтай байлдан, эзлэх бодлоготой байсан үе. Үүний дараагаар Хамаг Монгол улсаа, тулгар төрөө төвхнүүлж ард олноо амгалан энх амар аж төрөх бололцоо нөхцлөөр хангах нь гол бодлого байсны сацуу "Нууц товчоо", "Алтан товч", "Юан улсын бичиг" зэрэг түүхийн сурвалжуудад тэмдэглэснээр Чингис хааны хэлсэн үг бүрт төр улсын байдал тодорхой тусгагдаж байжээ.

Түүний "Алд бие минь алжаавал алжаатугай. Аху төр минь бүү алдартугай. Бүрэн бие минь зовбол зовтугай. Бүрэн улс минь бүү сандартугай" гэсэн хааны айлдварт Их Монгол улсынхаа тулгар төрийг бэхжүүлэх, улс орноо нэгтгэн төвхнүүлэхэд нөр их ажил бүтээх шаардлагатай байхад хааны эрүүл мэнд чилээрхүү насан өтөл болсноо илэрхийлсэн бололтой. Бас түүний "Сур дөрөө сунатал төмөр дөрөө дөлөртөл жийж их улсаа зовон зөөж зонхилон хураахуй цагт энэ мэт зовлонг эс үзвээ би" гэсэн айлдвартаа төрийн тэр их ажилд оролцож чадахгүй болсноо илэрхийлсэн болов уу. Тэгээд ч Чингис хаан их хааны залгамжаар өөрийн хүү Өгэдэйг хаан ширээнд суулгахаар товлосон үе байжээ. Харин Чингис хааны төрийн бодлогод Их Монгол улсын олон вант улс нь итгэл алдарч улс гүрнээ бутаргах буй хэмээн их болгоомжилж байсны учир хааны эрүүл мэндийн байдлыг нууцлах хэрэгцээтэй байсан үе тохиожээ. Тийм учраас Цагаадайд илгээсэн энэ зарлигт хэн өвдсөн, ямар өвчин туссан, ямар эм хэрэгтэйг заагаагүй байсны учир нь тэр нууц бодлоготой холбоотой байсан буй заа.

Бидэнд олдсон энэ зарлигийн гарсан хугацаа мэдэгдэхгүй байгааг зарлиг гарах үеийн улсын байдлаас ургуулан бодоход Чингис хаан өөрийн үндэслэн байгуулсан тулгар төрийг бэхжүүлэхэд нөр их ажил шаардагдах бөгөөд түүнийг гардан гүйцэтгэхэд биеийн эрүүл мэндээ сайжруулах нь тулгамдсан ажил болсныг тооцож үзээд амьдралынхаа сүүлийн жилүүдэд тухайлбал 1226-1227 оны үест зарлигласан болов уу гэж таамаглах үндэстэй юм. Түүхэн энэ үед Сартуулын олон ястан үндэстэн соёл иргэншил нь хөгжингүй байсны сацуу олон эмч мэргэжилтэнтэй, анагаах ухаан нэлээд чамбай хөгжсөн, тэгээд Цагаадай тэнд өргөмжлөгдөж суугаад тэр ард түмний соёл, анагаах ухааны ололт амжилтыг мэдсэн байхаар хугацаанд ажиллаад байсан учраас тэндээс эмчилгээний сайн арга ирнэ гэж үзэж Чингис хаан олон бага хаадынхаа дундаас Цагаадайд хандан зарлиг буулгасан байж болох юм.

Цагаадайд, их хаан эцгээсээ ирүүлсэн зарлигийг ёсоор болгоход тулгамдаж хэрэгжүүлэх хугацаа хэрэгтэй байсныг дараах үйл явц харуулж байна. Зарлигийн гол агуулга болох "эм бий буюу над өгч илгээ" гэсэн заалтын гүн агуулгыг мэргэн тайлж олох нь хамгийн зангилаа асуудал байжээ. тэр зарлиг ёсоор хэн өвчилсөн, ямар өвчин хүрсэн, ямар эм хэрэгтэй байгаа нь мэдэгдээгүй байна. Тиймээс төр улсаа хамгаалах хэрэгт амин сүнс болсон цэргийн хүрээнд өвчин гарч хэмээн ухаарч цэргийн бие бүрэлдэхүүн, түүний аж ахуйн хангалтын хэмжээнд тооцоолон, гарсан байж болох өвчний эмчилгээний домьг бүртгэж илгээсэн байна. Үүнийг Цагаадайгаас ирүүлсэн домд хамгийн олон нь мэс заслын эмчилгээний дом байгаагаас бас домын эцэст нууц хэмээн бичсэн баримтаас мэдэж болно.

Цагаадай хаан зарлигийн агуулгыг тогтоосны дараа зарлигт нийцсэн хариу бүрдүүлэхийн тулд түүнд хугацаа шаардагдах нь гарцаагүй байна. Их хааны зарлигийг авангуут хариу өгөх бололцоогүй байсныг эх бичигт Цагаадайн "жич илгээв" гэснээс мэдэгдэж байна.

Цагаадай хаанаас ирүүлсэн домын зүйлд олон талын шинжилгээ наад зах нь нэгээхнийг дурьдахад "шувууны хөл хавдваас үнэгний цөс түрхэх сайн" /30/ гэснээс үзэхэд Чингисийн цэргийн холбоонд шувуу ашигладаг байсныг гэрчлэх буйзаа. "Алтан товч"-д Хятадын Жуйн иргэнийг Боорч Мухлай хоёрт адил хувааж өгөхтүн. Авч сайн эрсээр нь шувуу бариулж дагуулж явагтун хэмээн Чингис хаан соёрхсон, бас Гүрвэлжин гоо хатан усны хязгаар явагч хөх болжмор барьж сүүлэнд нь бичиг бичиж "Би энэ усанд үхэх буй. Биеийг минь уруу бүү эр, өөд эр" гэж эцэгтээ илгээв гэсэн тэмдэглэл бий нь түүхийн давхар баталгаа болох юм.

Бас тэр үед цэргийн албанд эмэгтэйчүүд оролцдог байсныг мэдэж болох баримт бий.


Зарлигийн өөр нэг ач холбогдол бол Хамаг Монголын дагаар орсон улсуудын хооронд эмнэлгийн туршлага солилцох үйл ажиллагааны эхлэл болсон төрийн анхны шийдвэр болж байгаад оршино.

Цагаадайгаас ирүүлсэн домын зүйлд мэс заслын арга /53, 54, 55, 73, 75, 84/ байгаа бөгөөд "тархины яс хагарсанд ясы нь цоолоод тархинаас авч дундуурлаад хальсыг нь эвлүүлээд төөнө" /54/ гэсэн зүйл бол Монгол анагаах ухаанд тархины мэс заслын арга нэвтрэх анхны суурь 1226-1227 оны үед тавигдсаныг харуулж байна.


Энэ зарлиг бол монгол анагаах ухааны холбогдолтой зарлиг анх удаа олдсон ховор дурсгал байна.

Чингис хааны аж төрөн байсан үеэс их хойно тод үсэг буй болсон учраас тод үсгээр бичсэн энэ зарлиг бол яавч анхны эх биш гэдэг нь тодорхой байна.

Бидний толилуулан буй номын хэл нь баруун монголчуудын нутгийн аялгуу, эртний нэр томъёо үг хэллэг ихтэй, заримдаа нутгийн ардын үг хэллэгийг ойлгож буулгахад тийм ч хялбаргүй байсныг нэрэлхэх юун. Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймгийн зарим өндөр настан өтгөстэй уулзаж асууж мэдсэн минь их хэрэг болсон билээ. Дурьдваас олон жил аймгийн намын хорооны дарга, аймгийн дарга зэрэг алба хашиж байсан Увс аймгийн уугуул өндөр настан Заяат гуай нарын олон өтгөс тус болсонд талархаж байнам.



Уг сударын 25 v хуудас



Уг сударын 26 г хуудас

Жич: Энэхүү өгүүлэлийг бичихэд "Монголын нууц товчоон", "Алтан товч", "Юан улсын түүхийн бичиг", "Урианхай ардын домог" зэрэг эх сурвалж болон Жу Яотин-ы "Чингис хааны түүх шаштир" (2002) хэмээх номыг О. Адъяагийн орчуулгаар ашигласан болно.

